

Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэс

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ТӨСӨВ-2015





Улаанбаатар хот  
2016 он



Хан-Уул дүүргийн төсвийн орлого 2015 онд 47.4 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 2.0 тэрбум төгрөгөөр буюу 4.1 хувиар тасарсан байна. Харин дүүргийн орлогын бүрдэлт 2014 оныхоос 0.1 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Зураг 1. Төсвийн орлого, зарлага, сая.төг

Зураг 2. Төсвийн орлогын бүтэц, 2015 он, сая.төг



Төсвийн нийт орлогын 34.2 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, төлбөр хураамж), 3.8 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого), 62.0 хувийг тусламжийн орлого (улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг) тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Дүүргийн төсвийн орлого, 2015 он, сая.төг

	Төсвийн орлого			Үүнээс:								
	Бүгд	ТБ %	Зөрүү сая. төг	Татварын орлого			Татварын бус орлого			Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого		
				Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг
Дүн	47384.5	95.9	-2049.1	16232.7	95.6	-741.2	1787.5	68.6	-819.8	29364.2	98.4	-488.2

Хүснэгт 2. Дүүргийн төсвийн орлого, 2015 он, сая.төг


Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ, %	Зөрүү
Орон нутгийн орлого	49433.6	47384.5	95.9	-2049.1
1.Татварын орлогын дүн	16973.9	16232.7	95.6	-741.2
1.1 Орлогын албан татвар	5425.4	8320.0	153.4	2894.6
Хувь хүний орлогын албан татвар	5425.4	8320.0	153.4	2894.6
1.2 Хөрөнгийн албан татвар	5.6	9.9	176.8	4.3
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	11542.8	7902.7	68.5	-3640.1
Улсын тэмдэгтийн хураамж	10041.4	6853.8	68.3	-3187.6
Ашигт малтмал ашигласны төлбөр	75.3	28.6	38.0	-46.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1426.1	1020.3	71.5	-405.8
2.Татварын бус орлогын дүн	2607.3	1787.5	68.6	-819.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого	196.1	186.4	95.1	-9.7
Торгуулийн орлого	2351.2	1558.0	66.3	-793.2
Ангилалдаагүй бусад орлого	60.0	43.1	71.8	-16.9
3. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	29852.4	29364.2	98.4	-488.2
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	27356.5	27186.3	99.4	-170.2
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	2111.5	1784.8	84.5	-326.7
ТЗШ-р санхүүжих байгууллагын өөрийн орлого	384.4	393.1	102.3	8.7

Дүүргийн төсөвт 2015 онд 2607.3 сая төгрөгийн татварын бус орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 1787.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын төлөвлөгөө 819.8 сая төгрөгөөр буюу 31.4 хувиар тасарсан байна. Татварын бус орлогын 87.2 хувийг хүү, торгуулийн орлого, 10.4 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 2.4 хувийг ангилалдаагүй бусад орлогоос бүрдүүлжээ.


Татварын орлогын хэмжээ 16.2 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө төлөвлөснөөс 4.4 хувиар буюу 741.2 сая төгрөгөөр тасарсан байна. Орлогын голлох төрлүүдээр авч үзвэл 51.3 хувийг орлогын албан татвар, 48.7 хувийг өмчийн татвар болон бусад татвар /төлбөр хураамж/-ийн татвар тус тус эзэлж байна.

Бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 3.6 тэрбум төгрөгөөр тасарсан бол хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 4.3 сая төгрөгөөр орлогын албан татвар төлөвлөснөөс 2.9 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Зураг 3. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Зураг 4. Татварын орлогын бүтэц, хувиар




Тусламжийн орлогын хэмжээ 29.4 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 488.2 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар тасарсан байна.

Тусламжийн орлогын 92.6 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоос, 6.1 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн орлого, 1.3 хувийг тусгай зориулалтын шилжүүлэгээр санхүүжих байгууллагын өөрийн орлогоос бүрджээ.

Зураг 4. Тусламжийн орлогын бүтэц, хувиар



Зураг 5. Төсвийн зарлагын бүтэц, хувиар



2015 онд орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 95.2 хувийг буюу 42.6 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ.

Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 4.8 хувийг буюу 2.2 тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Төсвийн нийт зарлагын 47.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 5.2 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 3.9 хувийг татаас ба үрсгал шилжүүлэг, 43.6 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал, тус тус эзэлж байна.

Төсвийн зарлагын санхүүжилт 2014 онд 94.5 хувьтай байсан бол 2015 онд 95.2 хувь болж 0.7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. Дүүргийн төсвийн зарлага, сая.төг

	Орлогын дүн	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	47384.5	44792.5	42627.2	95.2	-2165.3	4757.3

Хүснэгт 4. Төсвийн орлого, зарлага сая.төг

	Төсвийн орлого		Төсвийн зарлага	
	2014 он	2015 он	2014 он	2015 он
Улсын төсөв	6 145 092.0	5 976 120.1	7 031 369.4	7 136 947.9
Улаанбаатар хот	812 369.1	844 759.6	770 138.0	883 794.3
Хан-Уул дүүрэг	47 325.3	47 384.5	42 428.1	42 627.2

2015 онд дүүргийн төсвийн орлого нийслэлийн төсвийн орлогын 5.6 хувийг, улсын төсвийн 0.8 хувийг бүрдүүлжээ. Хан-Уул дүүргийн нэг хүнд ногдох төсвийн орлогын хэмжээ 313.9 мянган төгрөгт хүрч өнгөрсөн оныхоос 28.8 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна.

Танилцуулга бэлтгэсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Л.Шинэтуяа